

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ  
8 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
үйл ажиллагааны мэдээлэл**

Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй, төрийн үйлчилгээний жил” болгон зарласантай холбогдуулан аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг томилон алслагдсан багийн иргэдэд төрийн үйлчилгээг цогцоор нь хүргэх арга хэмжээнд хамрагдсан 12 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт мэргэжил арга зүйн зөвлөмж хүргүүлж багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт тодорхой ажил зохион байгуулж ажиллахыг зөвлөв.

**Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл**

2019 онд улсын төсвийн хөрөнгөөр нийт 144.915.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 54 төсөл арга хэмжээ хэрэгжинэ. Үүнээс 2019 онд 42.262.3 сая төгрөгөөр санхүүжинэ. Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалалтаар 5 төсөл арга хэмжээнд 275.6 сая төгрөг батлагдсанаас 4 төсөл арга хэмжээ нь шинээр хэрэгжих 1 төсөл арга хэмжээ нь урд оны дутуу санхүүжилт байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 7.302.6 сая төсөвт өртөг бүхий 26 төсөл арга хэмжээ хэрэгжинэ. Үүнээс 2019 онд 3.011.6 сая төгрөгөөр санхүүжинэ. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3 төсөл арга хэмжээнд 132.7 сая төгрөг үүнээс барилга байгууламж 120.0 сая төгрөг, тоног төхөөрөмж 12.7 сая төгрөг тус тус тусгагдаад байна.

Засгийн газрын ивээл дор зохион байгуулсан "Хайртай" аяны хүрээнд Архангай аймагт 8-р сарын 4,5-ны өдрүүдэд хөвгүүдийн тархинд эх орон, гэр бүлээ хайрлах, эр хүн байх ухаан суулгах, түүх, уламжлал, эх орноо хамгаалах сэтгэлийг төрүүлж, омогшуулах, эерэг уур амьсгал төрүүлэх зорилготой "Урмаар тэтгээ" уулзалт, онцгой төрсөн ухаантай, хэрсүү хүүхдээр дамжуулан иргэдэд соён гэгээрүүлэх давалгаа бий болгох зорилготой "Оюунлаг, хэрсүү хүүхдүүд" 10-12 насны хүүхдийн уулзалт, бусдад үлгэр дууриал болох эгэл хүний амьдрал бахархлыг гарган харуулах зорилготой "Бахархалт эр хүн" телевизийн нэвтрүүлэг, контент бэлтгэх зэрэг арга хэмжээг тус тус зохион байгуулсан.

Мөн түүх соёлын болон байгалийн үзэсгэлэнт газруудыг сурталчилж, дотоодын аяллыг дэмжиж, эх орноороо бахархах сэтгэлийг төрүүлэх зорилгоор "Миний сайхан эх орон" нэвтрүүлгийг Архангай аймгаас бэлтгэж, 8-р сарын 05-ны өдөр "Хурд" хамтлагийн "Эх орны хийморь" тоглолтыг зохион байгууллаа.

БНХАУ-ын Юньнань мужийн Ардын их хурлын байнгын хорооны дэд дарга Ян Фушенг тэргүүтэй төлөөлөгчид Архангай аймагт айлчиллаа. Айлчлалын үеэр Архангай аймаг болон Юньнань мужийн хамтын ажиллагааны хүрээнд эдийн засаг, боловсрол, аялал жуулчлал зэрэгт салбарт хамтран ажиллах санал солилцлоо. Мөн Монгол улс

БНХАУ хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн зориулж аймгийн иргэдэд Юньнань мужийн жүжигчид дуу бүжгийн тоглолтоо толилуулсан байна.

БНСУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр Цэцэрлэг хотод дэвшилтэт технологийн Дулааны станц, дулаан дамжуулах шугам сүлжээ барих төслийг хэрэгжүүлэхээр шалгарсан БНСУ-ын “Ки-Ди-Эйч-И-Си” (KDHEC) компанийн төлөөлөл болон холбогдох мэргэжилтнүүд Дулааны станц, дулаан дамжуулах төвүүд ба дулаан дамжуулах шугамын зураг төслийг боловсруулах зорилгоор 8-р сарын 13-16-ны өдрүүдэд Архангай аймагт ажиллалаа.

Тус ажлын хүрээнд шинээр баригдах Дулааны станц, дулаан дамжуулах төвүүдийг барихаар төлөвлөж буй газрын байршил ба цахилгаан, цэвэр ус хангамж болон бохир ус зайлуулах системд холбох техникийн нөхцөл, дулаан дамжуулах шугамын трасс явах боломжит хувилбаруудыг судалж, газар дээр нь үзэж танилцсан байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас санаачлан аймгийн ЗДТГ, ХХААГ, “Нэг Архангай шинэ хөгжлийн тэмүүлэл” НҮТББ-тай хамтран “Сарлаг-Үндэсний нөөц баялаг” сэдвийн хүрээнд сарлаг үржүүлэгчдийн улсын зөвлөгөөнийг 8-р сарын 17-ны өдөр аймгийн төв Эрдэнэбулган суманд зохион байгууллаа.

Зөвлөгөөнд ХХААХҮЯ, МУСҮТ, ХААИС, МААЭШХ, Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн, Архангай аймаг дахь Өндөр уулын бүсийн хүрээлэн, Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Өвөрхангай, Завхан, Увс, Хөвсгөл, Ховд аймгийн ХХААГ болон зарим сумдын мал аж ахуйн салбарын мэргэжилтнүүд, малчид, саальчид, Монголын мал зүйч үржүүлэгчдийн холбоо, Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо, “Сарлаг” нийгэмлэг, Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо, Архангай аймгийн саальчдын холбоо, салбарын эрдэмтэн судлаачид, орон нутгийн мэргэжлийн байгууллага, мэргэжлийн холбоод, малчдын төлөөлөл оролцсон бөгөөд сарлагийн тархалтын хүрээг өргөтгөх, үржил, селекти, маллагааны арга технологийг оновчтой зохион байгуулах, төлөвлөх, сарлагийн сүү, мах, хөөвөр, хялгас бэлтгэл, удмын санг хамгаалах, үүлдэрлэг байдлыг сэргээн сайжруулах талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.

8-р сарын 18-ны өдөр “Монгол сарлаг-2019” фестивалийг Ихтамир сумын Тайхарын талд зохион байгууллаа.

“Монгол сарлаг-2019” фестивалийн хүрээнд Архангай аймгийн улсын аварга саальчдыг хамруулсан саальчдын бизнес уулзалтыг зохион байгуулж, “Сайхан сарлаг” /Ашиг шим өндөртэй сарлагийн бух/, “Арвин баялаг” /Хамгийн их сүүтэй үнээ/, “Сарлагт ээлтэй малчин” /ашиг шим, үүлдэр угсаа, түүхий эд бэлтгэл/, “Саглагар, сагсаахай” /Хамгийн их хөөвөр бэлтгэсэн хоршоо/, “Сүрлэг хангай” /сарлагийн хөсгийн үзүүлбэр/, “Ганган сарлаг” /тоног хэрэгсэл, чимэглэлтэй сарлаг/, “Шимт идээ” /Хамгийн сайхан амттай, сүүн бүтээгдэхүүн /, Хөөвөр, ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүн зэрэг номинациудаар шалгаруулж, сарлаг бугуйлдах тэмцээн, сарлагийн уралдааныг зохион байгуулсан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатаар ахлуулсан МХЕГ, ЦЕГ, ТЕГ, АМГТГ зэрэг байгууллагын ажлын хэсэг болон аймгаас томилогдсон Засаг дарга Ц.Мөнхнасангаар ахлуулсан ажлын хэсэг хамтран Цэнхэр сумын Орхон багт уул уурхайн олборлолт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд

тусгай зөвшөөрлийг цуцалсан тухай Засгийн газрын шийдвэрийг танилцуулж, тусгай зөвшөөрлийн лиценз цуцалсан актанд гарын үсэг зуруулан, үйл ажиллагааг нь зогсоож, тоног төхөөрөмж техник хэрэгслийг талбайгаас гаргаж, хиймэл нуурыг сэтлэн урсгах арга хэмжээ авсан байна.

8-р сарын 28-ны өдөр ДЭМБ-Номхон далайн баруун бүсийн Дархлаажуулалтын хөтөлбөрийн ахлагч доктор Такашима Ёошихиро, ДЭМБ-ын Монгол Улс дахь суурин төлөөлөгч доктор Сергей Диорица, ХӨСҮТ-ийн зөвлөх доктор Г.Сүрэнханд тэргүүтэй ажлын хэсэг Архангай аймагт дархлаажуулалтын хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцаж, Дэлхий нийтээр баримталж буй бодлого, чиглэлийг танилцууллаа.

Зөвлөлдөх уулзалтад сумдын Засаг дарга, Засаг даргын орлогч, аймгийн шийдвэр гаргагч нарыг хамруулж орон нутагт зорилтот насны хүн амыг 100% дархлаажуулалтад хамруулахад эрүүл мэндийн салбараас гадна орон нутгийн удирдлага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн идэвхи, хамтын ажиллагаа хамгийн чухал талаар хэлэлцсэн байна.

## **Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд**

### **Татвар төлөлтийн талаар**

Тайлант сард хүлээгдэж буй гүйцэтгэлээр улсын төсвийн болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 100.0 хувьтай байна.

Тайлант хугацаанд 7-р сарын нэмэгдсэн ертгийн албан татварын 213 тайлан цахимаар хүлээн авч тайлангийн ирцийг 100 хувьтай хангуулж, шалгуур үзүүлэлт хангаагүй байцаагчид хуваарилагдсан 19 тайланг тайлан хүлээн авах журмын дагуу хүлээн авч баталгаажуулж 12 иргэн, аж ахуйн нэгжид тендерт оролцох виз хүссэн, зээл авах, бусад төрлүүдээр лавлагаа тодорхойлолт гаргаж, цахимаар ирүүлсэн тайлан засварлах, хуулийн хугацаа сунгуулах, тоон гарын үсэг авах зэрэг 203 хүсэлтийг тайс системээр хүлээн авч шийдвэрлэлээ.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн 4 аж ахуйн нэгж, байгууллага, 2 иргэнийг “Татвар төлөгчийг бүртгэх журам”-ын дагуу хуулийн хугацаанд бүртгэн цахим тайлангийн системд хэрэглэгч үүсгэн татварын хууль тогтоомж, цахим тайлангийн талаар зөвлөгөө өгч хариуцсан байцаагчид мэдээллийг хүргүүлэн ажиллалаа. Татварын хэлтсийн facebook хуудасанд НӨАТ-ын тайлан ирүүлэх, ибаримтын тохиролын талаар 5 мэдээлэл бэлтгэн тавьсан.

### **Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагааны чиглэлээр**

Орон нутгийн өмчит 75 төсөвт байгууллагад 228.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авах, 7 төсөвт байгууллагад 436 нэрийн 75.7 сая төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрлийг тус тус олгосон байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар 17 асуудал оруулсан бөгөөд актлаж устгах 10, нэг байгууллагаас нөгөө байгууллагад шилжүүлэх 4, бусад асуудлаар 3 тогтоол гарсан байна.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 3.200.9 сая төгрөгийн 6 худалдан авалтын тендерийг зарласан бөгөөд тендер нь нээгдээгүй байна

## **Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд**

### **Иргэний бүртгэлийн чиглэлээр**

Шинээр төрсөн хүүхдээ бүртгүүлсэн төрөлт - 125  
Гэрлэлтийн бүртгэл - 16  
Гэрлэлт цуцалсаны бүртгэл - 0  
Хүүхэд үрчлэлтийн бүртгэл – 4  
Эцэг тогтоосны бүртгэл -4  
Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсөний бүртгэл - 4  
Нас баралтын бүртгэл - 39  
Шинээр иргэний үнэмлэх олгосон - 109  
Дахин олгосон - 56  
Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 165  
Үндэсний энгийн гадаад паспорт- 98  
Шилжилт хөдөлгөөн-95  
Иргэнд - 302 лавлагаа  
Хууль хяналтын байгууллагад – 35 лавлагаа

### **Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр**

Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 41  
Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 11  
Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл – 1  
Газар эзэмших эрхийн анхны бүртгэл – 0  
Арилжааны гэрээ – 1  
Худалдах худалдан авах гэрээ – 38  
Бэлэглэлийн гэрээ – 5  
Барьцааны эрхийн бүртгэл –312  
Өв залгамжлал – 2  
Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 6  
Лавлагаа – 8  
Бусад эрхийн бүртгэл – 6

Хууль хяналтын байгууллагад нийт 22 лавлагааг гарган хүргүүлсэн байна. Дээрх бүртгэлүүдийг хийж улсын төсөвт үйлчилгээний хөлс 2953135 төгрөг, тэмдэгтийн хураамжид 42116 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 7224000 төгрөг төвлөрүүлсэн байна.

### **Хуулийн этгээдийн чиглэлээр**

Шинэ-8

Өөрчлөлт-3

Тамга тэмдэгний хяналтын дугаар олгосон-14

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Цэнхэр, Өгийнуур, Хотонт, Тариат, Ихтамир сумын нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй 13 жуулчны бааз, 1 амралтын газарт эрүүл ахуй халдвар хамгаалал, байгаль орчин, газар, геодези, зураг зүй, хүнсний чанар, стандартын хяналтын чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалт болон зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ундны болон бохир ус цэвэрлэх байгууламжийн уснаас 49 дээж авч хими, нян судлалын шинжилгээнд хамрууллаа.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгч, улсын байцаагч нарын хамтарсан 116 заалт бүхий 7 зөвлөмж, 75 заалт бүхий 6 албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч 3 жуулчны баазад “Зөрчлийн тухай” хуулиар 1.600.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Шүүхийн шинжилгээний албанаас 8-р сард криминалистикийн шинжилгээ 2, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 7, шүүх эмнэлгийн шинжилгээ 64, тусгай шинжилгээ 27-г тус тус хийсэн байна.

Аймгийн хэмжээнд 8-р сард тус аймагт нийт гамшиг осол, аюулт үзэгдлийн 10 удаагийн дуудлага ирсний дотор объектын гал түймэр 3, гал түймрийн зөрчлийн дуудлага 4, үер усны дуудлага 3 удаа тус тус ирсэн байна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан авто үйлчилгээний байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулах удирдамжийн дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагуудад Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, гал түймрийн улсын хяналтын дүрэм, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулж, шалгалтад авто үйлчилгээний 8 байгууллагын 12 барилга байгууламжийг хамрууллаа.

Хяналт шалгалтын үеэр Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, норм, стандарт зөрчсөн, гал түймэр гарч болзошгүй 86 зөрчил илрүүлэн, газар дээр нь 9 зөрчлийг арилгуулж бусад зөрчлийг арилгуулахаар заавал биелүүлэх албан шаардлага 5, мэдэгдэл 3-ыг тус тус хүргүүлэн бусад зөрчлийг арилгуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 1987891 төгрөгийн мөнгөн дүн бүхий 489 гүйцэтгэх баримт бичиг ирснээс шийдвэр гүйцэтгэх бодит биелэлтийн хувь 41.6, мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлт 22.7 байна.

## **Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд Боловсролын чиглэлээр**

БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн газар хамтран бага, суурь, бүрэн боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн ЕБС-ийн багш, бага боловсролын сургалтын менежер, багшийн сургуулийн багш, сургуулиа төгссөн залуу багш нарт “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх арга зүй” сэдэвт сургалтыг 8-р сарын 13-18-ны өдрүүдэд Эрдэнэбулган суманд зохион байгуулж 1400 багш хамрагдсан байна.

8-р сарын 19-ний өдөр багш нарын бага хурлыг зохион байгуулж ерөнхий боловсролын 32 сургууль, хүүхдийн 35 цэцэрлэгийн төлөөлөл 200 гаруй багш, удирдах албан тушаалтнууд оролцлоо.

Бага хурлаар 2019-2020 оны хичээлийн жилийн зорилго, зорилтыг тодорхойлж, шинээр гарсан хууль, журмыг танилцуулан, тулгарч буй асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөмж, чиглэлийг өглөө.

## **Соёл урлагийн чиглэлээр**

Аймгийн Нийтийн номын сан нийтийн уншлагын танхимаар 30 уншигч шинээр бүртгэж, 170 ирэгсэдэд 210 ном, 95 сонин, сэтгүүлээр, гэрээр ном олгох үйлчилгээгээр 80 ирэгсэдэд 115 ном, 48 сонин, зөөврийн номын сангийн үйлчилгээгээр 38 уншигч шинээр бүртгэж, 155 ирэгсэдэд, 285 номоор тус тус үйлчилсэн байна.

Монгол оронд бүртгэгдсэн томоохон цогцолбор дурсгал болох Ихтамир сумын Цацын эрэг, Өндөр-Улаан сумын Их Жаргалантын буган хөшөө бүхий хүрлийн соёлын цогцолбор дурсгалуудыг Дэлхийн Өвд бүртгүүлэхтэй холбогдуулан ЮНЭСКО-гийн Хөшөө дурсгалт газруудын олон улсын зөвлөлөөс техникийн үнэлгээг 8-р сарын 14-22-ны өдрүүдэд Архангай аймагт хийлээ.

### **Эрүүл мэндийн чиглэлээр**

Аймгийн хэмжээнд 2019 оны эхний 7 сарын байдлаар нийт 188719 үзлэг хийгдсэнээс бодит тоогоор 73965 буюу 39.2 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 5 хүртэлхи насны хүүхдийн эндэгдлийн 22 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 22.9 ноогдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 тохиолдлоор буюу 1000 амьд төрөлтөд 4.8-аар буурсан байна.

Аймгийн хэмжээнд халдварт өвчний нийт 336 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 2 тохиолдлоор нэмэгдсэн.

Цочмог халдварт өвчин 126 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 12 тохиолдлоор буурсан. Архаг халдвар өвчин 210 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 14 тохиолдлоор нэмэгдсэн байна.

### **Биеийн тамир, спортын чиглэлээр**

Монголын хүүхдийн спортын 6-р наадамд Архангай аймгаас оролцох эрх авсан өсвөрийн баг тамирчид болон 2020 онд Азийн хүүхдийн спортын наадам Монгол Улсад зохион байгуулахтай холбогдуулан тамирчдын бэлтгэл сургуулилтыг хангах, тамирчдын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 8-р сарын 04-нөөс 14-ний өдрүүдэд “Чингисийн хүрээ” амралтын баазад бэлтгэл хийсэн. Уг бэлтгэлд Жүдо, Чөлөөт бөх, Бокс, Хөнгөн атлетик, Самбо гэсэн төрлөөр 60 гаруй тамирчин 6 дасгалжуулагч хамрагдсан.

### **Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр**

2019 оны 8-р сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 1339 иргэн бүртгэлтэй байгаагаас 689 эмэгтэй, Байнгын шинэ ажлын байр 560, түр ажлын байр 94, ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 557, зуучлал 533 байна. 8 сарын 20-ны байдлаар 114 иргэн нь шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан.

Шинэ ажлын байрыг эдийн засгийн салбараар нь ангилвал: Хөдөө аж ахуйн салбарт 212, боловсруулах үйлдвэрлэлд 239, Бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний салбарт 25, бусад салбарт 84 ажлын байр шинээр бий болсон байна. Ажлын байранд зуучлагдан орсон иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилвал: Хөдөө аж ахуйн салбарт 199, боловсруулах үйлдвэрлэлд 23, барилга 16, үйлчилгээний болон бусад салбаруудад 295 иргэн зуучлагдан орсон байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх Шивэрт ахмадын амралт нь 8-р сарын 01 нээс амрагч ахмадуудаа хүлээн авч эхэлсэн бөгөөд 135 ахмад настан амарч сувилуулаад байна.

Нийгмийн даатгалын санд 2019 оны 8-р сарын байдлаар нийт 11,2 тэр бум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 120 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 14,9 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 31,02 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 4173,7 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлжээ.

### **Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр**

Хүүхдийн “Тамир” зуслангийн 8-р ээлжинд 140 насанд хүрэгч, 20 хүүхэд нийт 160 амрагч амарсан бөгөөд нийт амрагчдын ая тухтай байдлыг хангах зорилгоор тэдний санал хүсэлт, үйл ажиллагааны хөтөлбөрийг “Хүүхэд-хөгжил”, “Гэр бүл-Хөгжил” хөтөлбөрийн 2, 3, 5, 7 хоногийн сүлжээ төлөвлөгөөтэй уялдуулж ажиллалаа.

### **Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд**

#### **Мал аж ахуй**

Аймгийн хэмжээнд 2019 онд 2365.1 мянган толгой хээлтэгч мал төллөхөөс 2000.1 мянган толгой мал төллөж 1943.6 мянган төлийг 97.2 хувьтай бойжуулж нийт эх малын 84.6 хувь нь төллөсөн. 44541 толгой том мал зүй бусаар хорогдсон нь нийт малын 0.8 хувь нь байна.

Улсын төсвийн хөрөнгөөр Тариат, Ихтамир, Хотонт, Цахир суманд Хотонт, Тамир үүлдрийн үржлийн хэсгийн 13.0 мянган толгой хонинд үзлэг ангилалт хийхэд цөм сүргийн үзүүлэлт хангасан 3745 толгой, үржлийн малын үзүүлэлт хангасан 4936 толгой, хэрэгцээний малын үзүүлэлт хангасан 2476 толгой хонь байна.

Мөн Тариат, Өндөр-Улаан, Хангай, Ихтамир сумын 5.0 мянган толгой сарлагт үзлэг ангилалт хийж цөм сүргийн малын үзүүлэлт хангасан 754 толгой, үржлийн малын үзүүлэлт хангасан 1225 толгой, хэрэгцээний малын үзүүлэлт хангасан 412 толгой малыг хамрууллаа.

2019 онд малчдын түвшинд 80.0 мянган тн байгалийн хадлан, 1300 тн гар тэжээл, аймаг сумдын аюулгүй нөөцөд 1400 тн өвс, 570 тн тэжээл, бэлтгэн нөөцлөхөөр төлөвлөн бэлтгэл ажлыг хангаж байна.

8-р сарын 20-ны байдлаар малчдын түвшинд 11.6 мянган тн өвс, 150 тн гар тэжээл бэлтгэсэн байна. Хадлан бэлтгэлийн ажил хийгдэж байна.

### **Газар тариалан**

2019 онд 9040 га-д үр тариа, 264.3 га –д төмс, 1097.9 га-д ногоон тэжээл, 650 га-д тосны ургамал, 126.5 га –д хүнсний ногоо нийт 11179 га талбайд тариалж, 10800 га талбайд уриншийн боловсруулалт хийсэн.

Жимс жимсгэнийн нэр төрлийг олшруулах, өөрийн орон нутгийн байгаль цаг уурын нөхцөлд нутагшуулах зорилгоор энэ оны хагас жилийн байдлаар шинээр чацаргана 15300 ширхэг, алим 210 ширхэг, чавга 200 ширхэг, нийт 15710 ширхэг жимсний суулгацыг 16 га талбайд тариалалт хийсэн.

Ургац хураалтын урьдчилсан балансыг тогтооход 1 га-гаас улаан буудай 11 цн буюу 10.0 мянган тн, төмс 110 цн буюу 2904 тн, тэжээлийн таримал 35 цн буюу 3800 тн, тосны таримал 7 цн буюу 455 тн, хүнсний ногоо 120 цн буюу 1512 тн ургац тус тус хураан авахаар төлөвлөж байна.

## **Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд**

### **Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр**

Хашаат сумын Цайдам багт жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Орхоны хөндийн бяцхан 99 баатрын аялал” аялал жуулчлалын эвент арга хэмжээг 8-р сарын 05–ны өдөр зохион байгуулж, арга хэмжээний үеэр 2 аймгийн 5 сумын 54 даага уралдаж, 16 хүртэлх насны 16 бөх, насанд хүрэгчдийн 24 бөх барилдаж, нум сум харваанд өсвөрийн 14 хүүхэд оролцлоо. Тус арга хэмжээнд 50 гаруй гадаад, 200 орчим дотоодын иргэд, орон нутгийн иргэд хамрагдлаа.

Мөн 8-р сарын 07-ны өдөр Хашаат сумын Цайдам багт “Орхоны хөндийн адуучдын баяр” аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулж, адуучдын ур чадварын тэмцээнд 23 адуучин оролцож, уурга шүүрэх, шургаа уурганы тэмцээн, морь булгиулах төрлөөр уралдаж, гадаад дотоодын жуулчдад зориулсан урлагийн тоглолт зэргийг зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд аяллын фото зурагчдын нэгдсэн групп ажилласан бөгөөд 43 жуулчин, 100 орчим дотоодын аялагч, орон нутгийн иргэд оролцсон байна.

8-р сарын 06-ны өдөр Ихтамир сумын Эрдэнэтолгой багийн Нарийн өлөнт гэх газар “Мод модлог ургамлын үржүүлэг” ХХК, Сум дундын ойн анги хамтран 50 га талбайд байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хийж гүйцэтгэлээ.

### **Барилга, дэд бүтцийн чиглэлээр**

2019 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 26.489.8 сая төгрөгийн өртөг бүхий 51 объектийн ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Батцэнгэл, Өлзийт, Өгийнуур, Хашаат, Хайрхан, Хотонт, Цэцэрлэг, Эрдэнэмандал сумдаас Улаанбаатар хотод суралцаж буй 500 оюутны байрны барилга, Өгийнуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсацыг сайжруулах ажил, Эрдэнэбулган сумын орон сууцны барилгын бохирын шугамын шинэчлэлийн ажил, Эрдэнэбулган сумын Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил, Тариат сумын 50 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, аймгийн Мал эмнэлгийн газрын барилга, Эрдэнэбулган сумын 1, 2-р 48 айлын орон сууцны барилгын гадна авто зогсоолын ажлын гүйцэтгэгчийг тус тус шалгаруулж гэрээ байгуулсан.

Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Эрдэнэбулган сумын 4-р сургуулийн барилгыг нэгдсэн бохирын системд холбох, Жаргалант сумын Хүүхдийн цэцэрлэгийн засвар, Өндөр-Улаан сумын Хануй багийн төвийн барилга, Тариат сумын Сумын төвийн шинэчлэлийн ажил, Цахир сумын Дотуур байрны барилгын засвар нийт 5 барилгын ажлыг ашиглалтанд хүлээж авсан